

БАТЛАВ: БОУАӨЯ-ны ХҮРЭЭЛЭН
БУЙ ОРЧНЫ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН
ДАРГА.....Г.ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРСӨН: “ЦЭГЭЭН ҮҮДЭН”
ХХК-ийн
ЗАХИРАЛ.....С.ЦЭРЭНДОНДОВ



**СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМЫН НУТАГТ
ОРШИХ “ТАЛ БУЛАГ 2” НЭРТЭЙ ХҮРЭН НҮҮРСНИЙ
ОРДЫН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-012466

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР: 2831686

ХЯНАСАН:

БОУАӨЯ-ны ХБОБХГ-ын ахлах шинжээч:.....Ц.Жаргалнэмэх

БОЛОВСРУУЛСАН:

“Цэгээн-Үүдэн” ХХК-ийн Маркшейдер:Ш.Шинэбаатар



АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА
2. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВАГДАЖ БУЙ ОРОН НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,
НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ
3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ,
ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД
ХИЙГДСЭН АЖЛЫН ТАЙЛАН
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖИЛ
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭМЖЭЭ
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ
14. НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ, ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТУХАЙН ЖИЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАГНАЛ
15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛ



1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

1.1 Ерөнхий мэдээлэл

Төслийн дугаар: 2023/ӨМ-34
Төслийн нэр: Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших Талбулаг-2
хүрэн нүүрсний ордыг ашиглах төсөл

№	Үзүүлэлтүүд	Мэдээлэл	
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Цэгээн-Үүдэн” ХХК	
2	Улсын бүртгэлийн дугаар	9011108112	
3	Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар	2831686	
4	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-012466	
5	Уурхайн нэр	Талбулаг-2	
6	Ордын нэр	Талбулагийн хүрэн нүүрсний орд	
7	Уурхайн байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Сүхбаатар аймаг
8		Сум/Дүүрэг	Сүхбаатар сум
9	Уурхайг ашиглаж эхэлсэн огноо		2014 он
10	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
11		Сум/Дүүрэг	Хан-Уул дүүрэг
12		Баг/Хороо	2-р хороо
13		Гудамж/Байр	Шаравын гудамж, өөрийн байр
14		Шуудангийн хайрцаг	-
15		Утас	91062222
16		Факс	
17		Гар утас	99111569
18		Электрон шуудан	sanjaatserendondov@mail.com
19		Вэб хуудас	-
20	Захирлын хаяг	Нэр	С.Цэрэндондов
21		Утас	
22		Гар утас	99111569
23		Электрон шуудан	sanjaa.tserendondov@mail.com
24	ТЭЗҮ батлуулсан огноо		2023 оны 01 сарын 27
25	Ашиглах хугацаа (ТЭЗҮ-ээр)		5 жил (11 жил)



1.2. Орд, уурхайн байршил

Талбулаг-2 нүүрсний уурхай нь Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт Улаанбаатар хотоос 520 км, Баруун-Урт хотоос 34 км, Сүхбаатар сумын төвөөс 84 км, Мөнххаан сумаас 60 км зайд оршино.

Зураг 1. Төсөл хэрэгжих газрын байршил



Талбулаг-2
Нүүрсний ил
уурхайн
байршил

“Цэгээн-Үүдэн” ХХК нь Сүхбаатар сумын нутагт орших Талбулаг нэртэй газарт орших 509.5 га талбайд MV-012466 тоот ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд нүүрс олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбицлууд

№	Координат	
	Уртраг	Өргөрөг
1	113° 03' 02.27"	46° 55' 01.75"
2	113° 03' 02.28"	46° 55' 51.76"
3	113° 04' 02.28"	46° 55' 51.76"
4	113° 04' 02.28"	46° 56' 31.76"
5	113° 02' 02.27"	46° 56' 31.76"
6	113° 02' 02.27"	46° 55' 01.75"

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1 Цаг уур, уур амьсгал

Тус орд орчмын нутаг дэвсгэр нь эх газрын эрс тэс уур амьсгалтай боловч үнэмлэхүй өндрийн хувьд нутгийн ихэнхийг нам дор, талархаг газар эзэлдэг учраас ерөнхийдөө дулаан уур амьсгалтай, хур чийг багатай, хуурайдуу уур амьсгалтай бүсэд багтана. Уур амьсгалд өвлийн цагт эсрэг циклон, зуны улиралд баруун зүгээс орж ирдэг циклон ихээхэн нөлөөлнө. Хамгийн бага агаарын температур дунджаар



1-р сард -21.6°C , хамгийн их агаарын температур 7-р сард $+21.5^{\circ}\text{C}$. Хоногийн дундаж агаарын температур намар орой 0°C -аас доош доош бууж хүйтрэх бөгөөд хавар нилээд эрт 0°C -аас дээш дулаарч эхэлдэг учир тус уурхай орчмын жилийн хүйтэн улирал 200-203 хоног байдаг. Хөрснөөс уурших чийгийн нөөц бага учраас дулааны улирлын жилийн дундаж харьцангуй чийгшил 30-60 хувь хүрнэ. 30%-аас бага чийгтэй хугацаа 51-62 өдөр байна. Жилдээ дунджаар 200-300 мм тунадас унадаг ба түүний ихэнх буюу 60-80 % нь зундаа 7, 8-р сард орно. Өвөлдөө хур тундсаар бага, жилийн дунджийн 1.5-3.0 % нь ордог ба цасан бүрхүүл удаан тогтохгүй ууршилын (сублимаци) улмаас үгүй болно. Тус бүс нутаг нь нийтдээ салхи ихтэй. Жилийн дундаж салхины хурд 4.5м/сек байдаг. Салхины хурд 20-40 м/сек хүрэх явдал цөөнгүй тохиолдоно.

2.2 Бүс нутгийн үйлдвэржилт, дэд бүтэц

Сүхбаатар аймаг нь 82.9 мян.км² нутаг дэвсгэртэй. Засаг захиргааны нэгжийн хувьд 13 сум, 67 багтай. Сүхбаатар аймаг нь хүн амын гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгалыг сааруулж, хүн амын өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, орон нутагтаа ажиллаж, амьдрах таатай орчин бүрдүүлэх, ажилгүйдлийн түвшинг бууруулах, цаашид аймгийн хөгжлийн давуу тал, нөөц боломжийг бүрэн ашиглаж, үйлдвэрлэл, үйлчилгээг бүх талаар дэмжин ажлын байрыг олноор бий болгох, эдийн засгийн өсөлт, тэргүүлэх салбаруудын хөгжил, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдсан хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогыг боловсруулан ядуурлыг эрс бууруулах зорилт тавин ажиллаж байна. Сүхбаатар аймгийн аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр:

- Эрдэс түүхий эдийн нөөцийг ашиглах үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх;
- Шинэ техник, технологи нэвтрүүлэх замаар бүтээгдэхүүний гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- Эрчим хүч, авто-зам, харилцаа холбоо, мэдээллийн сүлжээг хөгжүүлэх хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
- Аймгийн төвд Технологи дамжуулах төв байгуулах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;
- Хилийн гарц, боомтуудын үйл ажиллагааг улам сайжруулж, дотоодын хуримтлалыг эрс нэмэгдүүлэх;

“Цэгээн-Үүдэн” ХХК-ийн “Талбулаг-2” нүүрсний уурхай нь Сүхбаатар аймаг болон Дорнод бүсийн хөгжилд чухал нөлөө үзүүлэх, экспортын бүтээгдэхүүн гаргах боломжтой. Мөн түүнчлэн уурхай ашиглалтын үйл ажиллагаагаар шууд болон шууд бус ажлын байр бий болгон үйл ажиллагаа явуулж байна.

Тус аймагт зам харилцаа эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд 2014 онд Чингис хот-Баруун-Уртын хатуу хучилттай авто зам ашиглалтанд орсон. Цаашид хэвтээ чиглэлийн төмөр зам, Баруун-Урт-Бичигт чиглэлийн төмөр зам болон авто-замд холбогдсоноор ОХУ болон БНХАУ-тай харилцах таатай нөхцөл бүрдэхийн хамт бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Сүхбаатар аймаг нь харилцаа холбоо, мэдээллийн өргөн сүлжээнд хамрагдсан. Баруун-Урт хот нь Дорнод бүсийн эрчим хүчний системтэй 110 кВ-ын өндөр хүчдэлийн шугамаар холбогдсон бөгөөд тус уурхай нь Баруун-Уртаас Талбулагийн 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбогдсон тул уул уурхайн олборлолт, үйлдвэрлэл явуулахад дэд бүтцийн давуу талтай байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Талбулаг-2 нүүрсний ордыг ашиглах төсөл нь “Цэгээн-Үүдэн” ХХК-ийн санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх, улс, орон нутгийн нийгэм, эдийн засаг, дэд бүтэц, гадаад худалдааг хөгжүүлэх, иргэдийг ажлын байраар хангах зэрэг чухал ач холбогдолтой боловч төсөл хэрэгжих шатанд байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, уурхайн ашиглалтын нөлөөгөөр эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх, ажиллагсдын болон оршин суугчдын эрүүл ахуйг хамгаалах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлага тавигддаг.


3.1 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах

Агаарын чанар

Ухаж ачих, нүүрс бутлах, ангилан ялгах ажил, уулын цулын тээвэрлэлтээс тархах тоос, шороо уурхайн агаар орчныг бохирдуулах гол эх үүсвэр болж байна.

Агаар бохирдуулагч хорт хийн эх үүсвэр нь экскаватор, автосамосвал, бульдозер, дугуйт ачигч, дизель станц зэрэг дотоод шаталтат хөдөлгүүр бүхий тоног төхөөрөмжүүдийн яндангаас гарах утаа байна. 2024 оны уулын ажилд уулын цулыг сийрэгжүүлэх өрөмдлөг, тэсэлгээний ажил хийгдээгүй бөгөөд түүнээс ялгардаг хорт хийн нөлөөлөл агаарын чанарт байхгүй харин нүүрсний өөрөө шаталтаас гарах хорт утаа агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болдог. Нүүрсний өөрөө шаталтаас гарах хорт хий, угаар, үнс нурмын тоосролтыг тухай бүр хөрсөөр хучиж унтраах, усаар шүршиж намжаах арга хэмжээ авч ажилласан.

Зураг 2. Өөрөө шатаж дууссан нүүрсний ануулах



Ухаж ачих ажил: Экскаватор болон дугуйт ачигчаар хөрс, нүүрсний мөргөцгийг ухаж ачих үед ажлын талбай орчимд их хэмжээний тоосжилт үүсэхээс гадна уурхайн агаар орчныг бохирдуулдаг. Иймд мөргөцөг болон зам талбайг байнга тэгшилж автогрейдерээр сул шороог хусч зайлуулан тоосжилтыг бууруулах ажил тогтмол хийгдэж байна.

Тээвэрлэлт: Хөрсний чулуулаг болон нүүрс тээвэрлэх үед уурхайн агаар орчинд маш их тоос тардаг учир авто замыг байнга услах, сул шороо, чулууг хусч зайлуулах, замын арчилгааг сайтар хийж ажилласан. Уурхайн үндсэн амуудаар гарах байнгын замуудыг нүүрсний үндсэн давхарга хоорондын цементлэг чулуугаар хучиж сайжруулан нягтаршуулж тоос шороог багасгах, тогтмол чийглэж тоосжилтыг бууруулах, аль болох бага түвшинд байлгах техник зохион байгуулалтын арга хэмжээг өдөр тутам, ээлж хоногийн уулын ажилд хэрэгжүүлэн ажилласан.

Зураг 3. Уурхайн талбайд тоосжилт бууруулах зам усалгаа, кемп орчимын зам арчилгаа.



Тээвэрлэлтийн үед уурхайд тархах тоос нь тээврийн хэрэгслийн явах хурдаас хамааралтай байдгийг харгалзан хурдны хязгаарлалтыг дараах байдлаар хийж уурхайн үйл ажиллагаанд мөрдүүлэн ажиллаж байна. Үүнд: Уурхай-кемпийн орчинд баримтлах дээд хурд 50 км/цаг, уурхайн технологийн замд мөрдөх дээд хурд 40 км/цаг, уурхайн догол, түвшин, үндсэн налуу аманд 30 км/цаг, отвал болон мөргөцгийн замд 20 км/цаг, засварын газар, кемп, паркийн талбайд 10 км/цаг хурдны хязгаарлалтыг мөрддөг.

Уурхайд ажиллах тоног төхөөрөмжүүдийн хөдөлгүүрээс гарах хорт хийг хүлцэх хэмжээнд байлгахад техникийн бүрэн бүтэн байдал чухал байдаг. Иймд техник, тоног төхөөрөмжийг тогтмол үзлэг оношилгоонд оруулж, засвар үйлчилгээг 100, 500, 1000 мотоцаг тутамд графикаар хийж хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг бууруулж байна.

Нүүрсний өөрөө шаталт: Нүүрсний өөрөө шаталтаас урьдчилан сэргийлэх, өгөршлийн бүсэд халалт үүссэн галын цэгийг даруй дарж унтрааж байна.

Нүүрсний тоос болон метан хий: Талбулаг-2 нүүрсний ил уурхайд нүүрсний давхаргын далд малталт болон нүүрс дамжуулах, боловсруулах битүү барилга байгууламж одоогоор байхгүй тул нүүрсний тоос, метан хий хуримтлагдах тэсрэх аюул үүсдэггүй.

Уурхайн агааржуулалт: Ил уурхайн орон зайд агаарын урсгалын олон янзын зүй тогтол ажиглагдах бөгөөд байгалийн хүчний энэ хөдөлгөөнийг ашиглан ил уурхайд агааржуулалт хийх хэд хэдэн схем байна. Уурхайн байгалийн агаарын урсгал нь салхины хүчээр болон дулааны үйлчлэлээр явагдаж байдаг. Уурхайн гүнд салхины урсгалын хүч үйлчлэхгүй нөхцөлд уурхайн ёроол дахь агаар тогтонгиших нөхцөл үүсэх бөгөөд уурхайн ёроолын гадаргуу халсан нөхцөлд ёроолын агаар халж улмаар хүйтэн агаараар сэлбэгдэж хөдөлгөөнд орон уурхайг агааржуулна. Салхины хангалттай урсгал, түүний энергийн тусламжтайгаар ил уурхай сайн агаарждаг бөгөөд ил уурхайн орон зайнаас бохирдсон агаарыг сэлгэх нөхцлийг бүрдүүлнэ.

Талбулаг-2 уурхай нь зүүн хойноос баруун урагш чиглэсэн сунал бүхий хөндийд байршилтай тул байгалийн урсгалаар бохирдсон агаарыг сэлгэж уурхайг агааржуулах боломжтой юм.

Экскаватор, бульдозер, автосамосвал зэрэг уулын ажлын бүх тоног, төхөөрөмжүүд нь бүгд агаарын температур тохируулагчтай байдаг.

3.2 Хөрсөн бүрхэвч

Шинээр олборлолт, ашиглалт (гадаад болон шимт хөрсний овоолгын суурь, барилга байгууламжийн суурийн талбай, авто зам г.м)-д өртөх газруудын өнгөн хөрсийг хуулахдаа үржил шимт хөрс болон түүний доод



“Тал булаг 2” нэртэй нүүрсний ордын 2024 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

үеийн шимэрхэг хөрсийг тухайн үеүдийн онцлогоос хамааруулан 20-25 см хүртэл зузаантай хуулж тусад нь овоолон нөхөн сэргээлтийн ажилд ашиглахад нөөцлөн хадгалж байна.

Зураг 4. Шимт хөрсний 1-р овоолго.



Уурхайн олборлох үйл ажиллагааны нөлөөнд өртсөн хурдас чулуулгийн овоолго буюу уурхайн баруун овоолгын огцом налуу хажууг хэлбэршүүлэн засч техникийн нөхөн сэргээлт хийх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. Үүний дараа биологийн нөхөн сэргээлтийн ажлаар олон наст өвслөг болон буурцагт ургамал тариалж талбайг хөрсжүүлж, ургамлан нөмрөгтэй болгох ажлууд хийгдэнэ.

Зураг 5. Техникийн нөхөн сэргээлт хийж буй талбай.


**СҮХБААТАР АЙМГИЙН
СҮХБААТАР СУМЫН
ЗАСАГ ДАРГА**
22030 Хайлаастай, Сүхбаатар сум


2023 09 27 № 1/242
Танай _____ ны № _____

ТАЛЫН ГАЛ ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ С.ЦЭРЭНДОНДОВ ТАНАА

Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тавдугаар хэсгийн 5.1.8-д "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ" гэсэн шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор танай компанийн хүсэлтийг үндэслэн хүрэн нүүрсний олборлолтод өртсөн 7,98 га газарт техникийн нөхөн сэргээлт хийхийг зөвшөөрч байна.


ЗАСАГ ДАРГА Б.БАТХҮРЭЛ

Д/Бичиг хэрэг-2023 А5 албан тоот/





“Тал булаг 2” нэртэй нүүрсний ордын 2024 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Олон салаа зам гаргахгүй байх, ашиглалтанд өртөхгүй талбайг эвдрэлд оруулахгүй байхад ажлаа чиглүүлэн ажиллаж байна.

Зураг 6. Зам талбай, тэмдэг тэмдэглэгээ.





“Тал булаг 2” нэртэй нүүрсний ордын 2024 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэхдээ “Уул уурхайн улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал” болон бусад холбогдох журам, заавар, стандарт зэргийг мөрдөнө.

Мөн техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг шимт хөрсөөр хучихын өмнө “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008” стандартын дагуу бохирдуулагч бодис, элементүүдийн агууламжийг тодорхойлуулж холбогдох арга хэмжээг авах, техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг аль болох богино хугацаанд шимт хөрсөөр хучиж ургамалжуулна. Энэ нь хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлыг хадгалах нөхцлийг бүрдүүлэх ач холбогдолтой.



Уурхайн бүс, уулын ажлын талбайд шатах тослох материал, нефтийн бүтээгдэхүүнээр хөрсийг бохирдуулахгүй байх, сэргийлэх үүднээс хадгалалт, түгээлтэд онцгой анхаарч, түүнийг асгарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд химийн хортой болон аюултай бодисыг тусгайлан хадгалах складыг сэргээж шал, гадна хаяаг цементэлж тусгаарласан.

Зураг 7. Аюултай хог хаягдалын агуулах.



Уурхайн үйл ажиллагаанаас гарах хатуу хог хаягдлыг төрөлжүүлэн ялгаж ангилан зориулалтын цэгт түр хадгалан өөрийн тээврийн хэрэгслээр гэрээт байгууллагын нэгдсэн хогийн цэгт зайлуулах арга хэмжээг авч байна.

Зураг 8. Хатуу хаягдал хаях хогийн сав.



3.3 Газрын гадарга, хэвлий

Уурхайн ашиглалтаас үүдэн бий болсон газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

Уурхайн хөрсний гадаад овоолгуудыг салхины ноёлох чиглэлд хөндлөн байрлалтайгаар үржил шимт хөрсний овоолгыг 3 м-ээс ихгүй өндөртэй, овоолгын тогтворжилтын өнцөг 18 градусас ихгүй, оройн хэсгийг орчны гадаргын төрх байдалтай ойролцоо байхаар байгуулж хэлбэршүүлсэн.

Зураг 9. Шимт хөрсний 2-р овоолго.



- ☆ Олборлолтонд өртсөн газрыг “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтэд MNS 5917:2008” стандартыг мөрдлөг болгон нөхөн сэргээх ажил үргэлжлэн хийгдэнэ. Дотоод овоолго хийх боломжтой газруудыг дүүргэж техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх зорилгоор уурхайн ашиглалт явагдсан 7.98 га талбайд нөхөн дүүргэлт хийх ажлыг эхлүүлээд байна.

Зураг 10. Техникийн нөхөн сэргээлт хийж буй талбай.



- ☆ Хөрс болон нүүрсний догол, мөрөгцөг, уурхайн болон овоолгын хажууг уулын ажлын паспортод тусгасан хэмжээ, параметрийн хүрээнд уулын ажлыг явуулж байна.



Зураг 11. Ажлын талбай.



- ☆ Уурхайн ирмэг болон хөрсний гулсалт, нурал үүсч болкошгүй газарт хаалт, хөмсөг, далан тавьж хамгаалан уулын ажлыг өргөжүүлж байна.
- ☆ Үер, уснаас хамгаалах зорилгоор гадаргын хэвгий дагуулан залах шуудууг уурхайн бүсийн урд хязгаар дагуу 500м татаж тусгай зөвшөөрлийн хилийн дагуу шуудуу татаж далангаар бэхжүүлэн хамгаалсан.

Зураг 12. Үерийн усны хамгаалалтын шуудуу, далан.





- ☆ Отвалын ирмэг дагуу ан, цав гарсан хэсэгт болон цэвэрлэгээний хаягдал нүүрсний хольц бүхий өөрөө шаталт үүсч болзошгүй, уугиж асах магадлалтай хэсгийг шаварлаг хөрсөөр дарж агаар нэвтрэхээс хамгаалдаг.
- ☆ Нээгдсэн нүүрсний өгөршил, исэлдэлтэнд орсон сааж нүүрс, нунтаг гуминтай нүүрсийг хаягдалгүй, иж бүрэн ашиглах зорилгоор цэвэрлэгээний үеийн шавар, завсрын хөрсний бага бохирдолтой нүүрсийг тусгайлан “Угаах нүүрсний овоолго” үүсгэн нөөцөлсөн. “Нүүрс угаан баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ”-ийг мэргэжлийн байгууллагаар боловсруулан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралд хэлэлцүүлэн батлуулсан. Хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдсэн тохиолдолд Нүүрс угаан баяжуулах үйлдвэр байгуулан “Угаах нүүрсний овоолго”-д нөөцөлсөн, хөрсний бохирдолтой, хаягдах нүүрсийг угаан ялгаж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болгох, нөөцийг иж бүрэн ашиглах, борлуулалтын орлогыг өсгөх эдийн засгийн бодит үр ашигтай ажил болно. Мөн “Угаах нүүрсний овоолго”-ын хормойд өөрийн жингээр ялгарч буусан бүхэл, том ширхэгтэй нүүрсийг сум, орон нутгийн иргэд, хэрэглэгчдэд ялган борлуулах боломж бүрдэж байгаа нь ашигт малтмалыг хаягдалгүй олборлох ажил болж байна.
- ☆ Уурхайн уулын ажлын хөрс хуулалтанд өртөж байгаа нягт ширхэгтэй, даац авдаг цагаан шавар, сул цементлэг аргиллитын чулууны үеийг уурхайн үндсэн болон технологийн замын хучилт, барилга, байгууламжийн суурийн бэлдэц болгон ашиглаж байна.
- ☆ Талбулаг-2 уурхайн 2024 оны уулын ажлаар Сүхбаатар аймаг, сум, орон нутгийн түлш, нүүрсний хангамжийг бүрдүүлж дотоодод борлуулах нүүрс олборлолтонд хөрс хуулалтын коэффициент $K_{хх}=2.0$ м³/тн, экспортын зориулалтын нүүрс олборлолтонд $K_{хх}=4.0$ м³/тн, нийт уулын цулын дунджаар $K_{хх}=3.0$ м³/тн байхаар тооцож уулын ажлыг явууллаа.

Уурхайн 2024 оны уулын ажлаар бүрэн ашиглагдаж дууссан талбай гараагүй байгаа учир тодорхой талбайг бэлчээрийн зориулалтаар нөхөн сэргээх, үүний тулд эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулах, хортой бодис илэрсэн тохиолдолд хурдас чулуулгийн хорыг саармагжуулах, хоргүйжүүлэх арга хэмжээ, ажил хийгдээ эхлээгүй байна.

3.4 Гадаргын болон газрын доорх ус

Талбулаг-2 уурхай нь 2024 онд ажиллагсдын унд-ахуйн хэрэгцээний усыг уурхайн кемпэд байрлах гүний худгаас ус цэнгэгжүүлэх төхөөрөмжөөр шүүж ашигласан бөгөөд шаардлагатай нөхцөлд Баруун-Уртаас савласан цэвэр ус захиалгаар авч хэрэглэдэг. Технологийн хэрэгцээний усыг уурхайн ус шүүрүүлэлтийн усан сангаас ашигладаг.

Худгийн усны лабораторийн шинжилгээний дүнг тайлангийн бүрдэлд хавсаргана.

Талбулаг-2 уурхай нь 2024 оноос уурхайн ёроолд хаврын шар ус, дулааны улирлын хур тунадас, их хэмжээний аадар бороо, үерийн нөлөөгөөр хуримтлагдаж бий болсон тогтоол ус, нуурын ус таталт, шавхан зайлуулалтын ажлыг 09-р сараас хийж эхэлсэн. Тогтоол нуурын усыг соруулах зумпф байгуулан түрэлтийн насосоор шавхан газрын гадаргын хэвгийгээр чөлөөт урсацаар байгальд гадагшлуулж уурхайн талбайн баруун хойд талд байрлах тогтоол усны нууранд цутгах ажлыг хийж гүйцэтгэсэн. Технологийн замын тоос дарах зориулалтаар усалгаанд ашигласан.

Ил уурхайн талбай Талбулагийн рашаанаас 10км зайд байрладаг учир уулын ажлын сөрөг нөлөөлөл үзүүлдэггүй.

3.5 Ургамлан нөмрөг

Талбулагийн нүүрсний уурхай орчмын ургамлан нөмрөгийн доройтлыг багасгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна.

- ☆ Орд орчмын ургамалжилтын өөрчлөлтийг хянаж байхын тулд Сүхбаатар аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газартай гэрээ байгуулж жилд 2 удаа хөрс, ус, агаарт орчны шинжилгээ хийлгэж байна.



- ☆ Уурхайн хөрс хуулалтанд өнгөн хэсгийн ургамал өртөж усах, үгүй болох, овоолго, барилга байгууламжийн доор ургамал дарагдах, авто замд эвдэгдэх зэрэг сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор уурхайн баруун овоолгын өндрийг хүрээний дагуу намсган 18 градусаар налуулах ажил хийгдэж байна.
- ☆ Уурхайн олборлолт явуулж байгаа хэсэг, үндсэн зам талбай, ойролцоо газруудад тоосны хуримтлал үүсэхээс сэргийлж усалгааны зориулалтын шүршигчтэй машинаар зам талбайг тогтмол усалж байна.
- ☆ Шатах тослох материал, машин механизмын засварын газар болон уурхайн тосгоны газрыг эмх цэгцтэй зохион байгуулах, орчныг бохирдуулахгүй байх хяналт тавьж ажилласан масло тосыг цуглуулж хадгалах, халаалтын зууханд түлшний зориулалтаар ашиглах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.
- ☆ Зам талбайн арчилгаа, усалгаа тордолтыг Авторгрейдер, усалгааны машинаар ээлж тутамд тогтмол хийж байна.
- ☆ Ургамлын доройтол үүсч бий болох магадлалтай газар одоогоор тодорхойлогдоогүй байгаа учир хил хязгаар тогтоох, хамгаалах ажил хийгдээгүй.
- ☆ Шимт хөрс хуулалт, хадгалалт, хамгаалалтыг стандартын дагуу гүйцэтгэн ажиллаж байна.
- ☆ Биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй байгаа тул нутгийн унаган ургамал болон тухайн нутгийн онцлогт тохирсон ургамлын сорт, үр сонгох тариалах ажил эхлээгүй байна.

3.6 Амьтны аймаг

Нүүрс тээвэрлэлт болон уул уурхайд ажиллах машин техникүүдэд дуу чимээний хязгаарлалт хийх ялангуяа амьтны биологийн идэвхит цаг хугацаанд /ороо хөөцөө, нүүдэллэлт, бэлчээрлэлт гэх мэт/ илүү анхаарч уурхайн кемпийн бүсэд мод бут тарьж арчилгаа, усалгааны ажил хийж байна.

- ☆ Тоосжилтийг бууруулж хуурайшилт ихтэй үед зам талбайг тогтмол усалдаг.
- ☆ Уурхайгаас гарах хатуу хог хаягдлыг зориулалтын хогийн цэгт төвлөрүүлэх, шингэн хаягдлыг ил задгай хаяхгүй, бохирын цооногт зайлуулах, амьтны бэлчээр, усанд ордог булаг шандын ойролцоо газар бохирдуулах, хог хаяхаас сэргийлэн ажиллаж байна.

Зураг 13. Кемп орчим.





3.7 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

Бүс нутгийн байгаль, цаг агаарын онцлог, хүрээлэн буй орчны унаган төлөв байдалд нийцүүлэн дүйцүүлэн хамгаалах чиглэлээр тодорхой газар, талбай, хэрэгжүүлэх ажлын санал авах тухай Сүхбаатар сумын Засаг даргад хандсан бөгөөд тодорхой санал, хүсэлт, ажлын даалгавар ирээгүй учир Талбулаг-2 уурхайн 2024 оны үйл ажиллагаанд байгаль орчныг дүйцүүлэн хамгаалах ажил хийгдээгүй.

3.8 Нөхөн сэргээлтийн арга хэмжээ

Талбулаг-2 нүүрсний уурхайн үйл ажиллагаанаас эвдрэлд өртөх газрыг бэлчээрийн зориулалтаар нөхөн сэргээх шаардлага тавигддаг. Иймд уурхайн үйл ажиллагаанд өртөх талбайн 95 орчим хувийг бэлчээрийн зориулалтаар, 5 хувьд мод, бут, хүнсний ногоо тарих байдлаар нөхөн сэргээх боломжтой гэж БОННУ-ний зөвлөмжид тусгасан байдаг. Эхний ээлжинд уурхайн тосгонд мод тарих, ажилчдын хүнсний хэрэгцээнд төмс, хүнсний ногоо болон төрөл бүрийн ургамлын үрийг турших цаашид нөхөн сэргээлтэнд тохирох ургамлыг сонгон тариална.

Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг техникийн болон биологийн нөхөн сэргээлт гэсэн 2 үндсэн дарааллаар хийж гүйцэтгэнэ.



3.9 Байгаль орчинд үзүүлж болзошгүй эрсдлийн үнэлгээ

Хүснэгт 2. Байгаль орчинд учирч болзошгүй эрсдлийн үнэлгээний матриц

№	Нөлөөлөл	Нөлөөллийн цар хүрээ	Бага	Дунд	Их	Онцгой их
1	Гал түймэр гарах	Зайлшгүй болох				
		Болох магадлалтай				
		Болзошгүй			+	
		Болох магадлал бага				
		Болохгүй				
2	Шатах тослох материалын хадгалалт	Зайлшгүй болох				
		Болох магадлалтай			+	
		Болзошгүй				
		Болох магадлал бага				
		Болохгүй				
3	Хог хаягдлын зайлуулалт	Зайлшгүй болох		+		
		Болох магадлалтай				
		Болзошгүй				
		Болох магадлал бага				
		Болохгүй				
4	Ашиглалтын технологичерчиг	Зайлшгүй болох				
		Болох магадлалтай			+	
		Болзошгүй				
		Болох магадлал бага				
		Болохгүй				
5	Тоосжилт	Зайлшгүй болох			+	
		Болох магадлалтай				
		Болзошгүй				
		Болох магадлал бага				
		Болохгүй				
6	Дуу шуугиан	Зайлшгүй болох		+		
		Болох магадлалтай				
		Болзошгүй				
		Магад болохгүй				
		Болохгүй				
		Маш бага эрсдэлтэй				
		Хүлцэж болох эрсдэл				
		Эрсдлийг бууруулж болохуйц				
		Эрсдлийг зайлшгүй бууруулах				

Дээрх хүснэгтээс харахад төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч болзошгүй 6 сөрөг тохиолдол байна. Үүнээс:

- ☆ Их эрсдэлтэй, тохиолдож болзошгүй 1 тохиолдол
- ☆ Их эрсдэлтэй, болох магадлалтай 2 тохиолдол
- ☆ Их эрсдэлтэй, зайлшгүй болох 1 тохиолдол
- ☆ Дунд эрсдэлтэй, тохиолдох зайлшгүй болох магадлал 2 тохиолдол тус тус тохиолдох магадлалтай.

Нийт эрсдэл нь тохиолдол магадлал багатай ч хэрэв эрсдэл учирсан тохиолдолд байгаль орчинд үзүүлэх эрсдлийн хэмжээ өндөр байна.



“Тал булаг 2” нэртэй нүүрсний ордын 2024 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, БИЕЛЭЛТ
	1	2	3	4	5	6	7	8	9
Агаарын чанар:									
1.1	Уурхайн олборлолт болон тээвэрлэлтгээс тооосжилт үүсэх.	Ордын дотоод тээвэрлэлтийн замд тооосжилт бууруулах шинэлэг технологи нэвтрүүлэх	Уурхайн ашиглалтын талбай	-	-	-	Үйл ажиллагааны зардалд орсон	Өдөр, шөнийн ээлж тутамд	Уурхайн дотоод тээврийн замд усан буугаар шүрших тоноглолтой, цацаргах усалгааны зориулалттай, 18 тонн савны багтаамжтай Dong-Feng маркийн усны машин ашиглан тооосжилтыг бууруулж ажилласан.
1.2		Зам ашиглалтаас үүссэн туйран, эвдрэлд тогтмол арчилгаа хийх.		Төг	-	-	500.000	Өдрийн ээлж бүрт	Зам ашиглалтын явцад үүссэн түйрэн, эвдрэлд Liu-Gong маркийн автогрейдер ажиллан арчилгаа, сайжруулалтыг тухай бүр хийж байна.
1.3		Хүнд машин механизмууд, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг байнга хийж, утааны яндангаас гарах хорт хийн хэмжээг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх		-	-	-	Үйл ажиллагааны зардалд орсон	Төлөвлөгөөт хуваарийн дагуу	Уулын хүнд машин механизм, тээврийн хэрэгслүүдэд 100, 500, 1000 мото-цаг тутамд Техник үйлчилгээг график хуваарийн дагуу хийж техник ашиглалтын байдалд үзлэг шалгалт хийдэг. Техник үйлчилгээ бүрт хөдөлгүүрийн масло шинээр солих, тос болон түлшний шүүр, агаар шүүгч солих ажлууд хийгдэнэ. Ээлж, ростер тутамд хөдөлгүүрийн цаасан болон тосон агаар шүүгчийг цэвэрлэн явцын хяналт тогтмол хийгдэж байна.
1.4		Нүүрсний өөрөө шаталтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах		-	-	-	Үйл ажиллагааны зардалд орсон	Тухай бүр	Уурхайн догол, мөргөцөг, хөрсний овоолго, нүүрсний складад өөрөө шаталт үүссэн тухай бүр хөрсөөр дарж унтраах, тасалж тусгаарлах, усаар шүршиж унтраах, булах арга хэмжээ авч ажилладаг.

[illegible]



“Тал булаг 2” нэртэй нүүрсний ордын 2024 оны БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН

3.1	Шатах тослох материалаар болон ашиглалтийн үеийн хөрс бохирдолт	Уурхайн малталтанд өртөх талбайн шимт хөрсийг ангилан хуулж, нар салхины нөлөөгөөр элэгдэхээс хамгаалах	Уурхайн ашиглалтын талбай	м ³	50,000	20.0	Үйл ажиллагааны зардалд орсон	Тухай бүр	Уурхайн 2024 оны уулын ажлын хойшоо ахилтанд шинээр өртсөн 9,1 га талбайн шимт хөрсийг ангилан хуулж шимт хөрсний овоолгод байршуулсан.
3.2		Шимт хөрсийг хуучин овоолгонд нэмж хадгалан нөхөн сэргээлт, ногоон байгууламжид эргүүлэн ашиглах, бүртгэл хөтлөх, тооцоог хянах		м ³			Үйл ажиллагааны зардал	Шимт хөрс хуулах, овоолго хийх, дахин ашиглах үед	Уулын ажлын шинэчилсэн төлөвлөлтөөр отвалын ахилтанд өртөх шимт хөрсний хуучин овоолгыг шилжүүлэн шимт хөрсний 2-р овоолгод нэгтгэн хэлбэршүүлсэн. Хөрсний зүүн отвалын зүүн тийш ахилтанд өртөх талбайн шимт хөрсийг ангилан хуулж нуруулдан тээвэрлэхэд бэлтгэсэн.
